

ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

дугаар 03

Монгол улсын компанийн тухай хуулийн 60, 62, 65-р зүйлийн холбогдох заалтууд, тус компанийн 2023 оны 01 сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Дархан нэхий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 03 сарын 04-ний өдрийн 12 цагаас Дархан-Уул аймаг Дархан сумын 14-р баг Дархан нэхий ХК-ийн охин компани болох Гранд як ХХК-ийн 2 давхарын хурлын заал 2001 тоот өрөөнд хуралдуулсугай.
2. ХЭХуралд доорхи асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.
Үүнд:
 1. Компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
 2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
 3. ТУЗ-ийн гишүүнийг сонгож батлах
 4. ТУЗ-ийн төсөв батлах / цалин урамшууллын хэмжээг тогтоох/
 5. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг батлах
 6. Дархан нэхий ХК-ийн дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэж батлах
 7. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн шинэчилсэн журмуудыг батлах тухай
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг: 2023 оны 02 сарын 09-ний өдрөөр тогтоосугай.
4. Олон нийтэд зарлах өдрийг 2023 оны 01 сарын 25, мөн 2023 оны 02 сарын 09-ны өдрөөр тус тус тогтоосугай.
5. Саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 02 сарын 28-ны өдрөөр дуусгавар болгосугай.
6. ХЭХурлын даргаар ТУЗ-ийн дарга /Х. Золжаргал/-ыг томилсугай.
7. Тооллогын комиссын даргаар Б. Орхончимэг, гишүүнээр Г. Эрдэнэтуяа, Д. Ариунболор нарыг тус тус томилсугай.
8. ХЭХ-ыг зохион байгуулах комиссын даргаар ДНХК-ийн ерөнхий захирал Б. Чинчулуун, гишүүнээр ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х. Нарантуяа нарыг тус тус томилсугай.
9. Хурлын бэлтгэл ажлыг компанийн тухай хуульд нийцүүлэх, ХЭ-дийн танилцах баримт бичиг, холбогдох материалыг хуульд заасан хугацаанд багтаан бүрдүүлж, бэлтгэхийг ДНХК-ийн удирдлагын багт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ